

АНУ-ЫН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД ТАРААХ ЗОРИЛГОГУЙ БОЛНО. ЭНЭХҮҮ ХЯЗГААРЛАЛТЫГ ЗӨРЧСӨНӨӨР АНУ-ЫН ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ ХУУЛИЙГ ЗӨРЧИХ МАГАДЛАЛТАЙ.

## ЭРДЭНЭ РЕСУРС ХААЛТТАЙ САНХҮҮЖИЛТИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ХИЙЛЭЭ

---

### Хэвлэлийн мэдээ

Нова Скошиа, Халифакс хот  
2020.07.30

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани” гэх) нь хаалттай санхүүжилтийн хүрээнд хийж буй \$20 сая кан.долларын хөрөнгө оруулалтын талаар мэдээлэл хийлээ.

Дээрх санхүүжилтийн хүрээнд тус бүрийг \$0.45 кан.доллараар үнэлсэн 33,333,333 нэгж захиалгын баримт (“Subscription Receipts”)-ыг ноён Эрик Спроттын эзэмшдэг хуулийн этгээд худалдан авч, түүнтэй зэрэгцэн тус бүрийг \$0.45 кан.доллараар үнэлсэн 11,111,111 ширхэг үнэт цаасны нэгжийг гаргасан. Захиалгын баримтууд нь үнэт цаасны нэгжид хөрвөх боломжтой бөгөөд үнэт цаасны нэгж бүр нь Компанийн нэг энгийн хувьцаа болон энгийн хувьцаа худалдан авах эрх болох нэг варрант (“Варрант”)-аас бүрдэнэ. Варрант бүр нь санхүүжилт хаагдсанаас хойш хоёр жилийн хугацаанд нэг энгийн хувьцааг \$0.60 кан.доллараар худалдан авах эрхийг олгоно. Тодорхой нөхцөлүүдийг биелүүлснээр захиалгын баримтууд нь нэмэлт нөхцөлгүйгээр үнэт цаасны нэгжид хөрвөнө.

Компанийн удирдлага, ТУЗ-ийн гишүүд болон охин компаниуд нь энэхүү санхүүжилтийн 1,111,111 ширхэг үнэт цаасны нэгжийг захиалан, нийт 2,222,222 гаргасан болон гаргах боломжтой энгийн хувьцааг худалдан авсан нь одоогийн гаргасан болон арилжигдаж буй Энгийн хувьцааны 1.2%-ийг төлөөлж байна. Үүнээс гадна үнэт цаасны нэгжийн захиалгатай холбоотойгоор 555,555 зуучлалын варрантыг гаргах магадлалтай.

Энэхүү хаалттай санхүүжилтийн хэлэлцээр нь сунгасан гарын зарчим (“Arm’s Length”)-аар хийгдсэн бөгөөд үнэт цаасны нэгж болон захиалгын баримтуудын ханш нь 2020 оны 7 сарын 23-нд хаагдсан Торонтогийн Хөрөнгийн Биржийн 5 өдрийн жигнэсэн дундаж ханшаас ойролцоогоор 12.4%-ийн хямдралтайгаар тогтоогдсон.

Энэхүү хэвлэлийн мэдээ гарах өдөр Компани нь нийт 192,937,702 Энгийн Хувьцааг гарган, арилжиж байна. Хаалттай санхүүжилттэй холбоотойгоор нийт 89,444,443 Энгийн хувьцаа (гаргах боломжтой энгийн хувьцаа, варрант, зуучлалын варрантуудыг оролцуулан)-г гаргах, гаргах боломжтой болох ба эдгээр нь одоогийн гаргасан, арилжиж буй энгийн хувьцааны 46.4%-ийг төлөөлнө.

Одоогийн байдлаар ноён Спротт нь Эрдэнэ Ресурсийн үнэт цаасыг эзэмшдэггүй. Хаалттай санхүүжилт хаагдан, захиалгын баримтууд нь үнэт цаасны нэгжид шилжсэнээр ноён Спротт нь компанийн

33,333,333 энгийн хувьцаа буюу хорогдуулаагүй хэлбэрээр гаргасан 237,382,146 ширхэг энгийн хувьцааны 14.0%-ийг эзэмшинэ.

Торонтогийн хөрөнгийн биржийн гарын авлагын 604(a), 607(g)(i) хэсгүүдэд тусгасны дагуу Компанийн хяналтад нөлөөлөх аливаа үнэт цаас гаргахтай холбоотой гүйлгээ, мөн гүйлгээ хийгдэж буй үнэт цаасны үнэ зах зээлийн үнээс бага байхаар тогтоосон бөгөөд нийт гаргасан, хорогдуулаагүй хэлбэрээр гаргаж байгаа үнэт цаас нь нийт гаргасан энгийн хувьцааны тоо хэмжээнээс 25%-аас дээш тооны энгийн хувьцаа гаргаж буй тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрлийг авах шаардлагатай. Эрдэнэ Ресурс нь ТХБ-ийн 604(d) хэсэгт заасан чөлөөлөх нөхцөлийн дагуу энгийн хувьцаа эзэмшигчдийн 50%-аас дээш тооны хувьцаа эзэмшигчдийн бичгэн зөвшөөрлийг авахаар ажиллаж байна.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь АНУ-д үнэт цаас худалдах саналыг агуулаагүй болно. Хаалттай санхүүжилтийн хүрээнд босгож буй энэхүү хөрөнгө оруулалтыг АНУ-ын үнэт цаасны акт болон бусад мужийн үнэт цаасны тухай хууль тогтоомж, бүртгэлээс чөлөөлөгдөх боломжтой иргэдээс бусад тохиолдолд АНУ-ын үнэт цаасны акт, аливаа мужийн үнэт цаасны тухай хуулийн хүрээнд санал болгоогүй бөгөөд ирээдүйд санал болгохгүй.

### Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Компани нь өндөр агуулга, бага зардал, анхан шатны хөрөнгө оруулалт багатай Баян Хөндий Алтны Төслийг хөгжүүлж байгаа бөгөөд 2022 оны эхээр алт олборлолтыг эхлэхээр төлөвлөж байна. Компани нь Монгол Улсын баруун өмнөд бүсэд хайгуул хийх эрх бүхий 3 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт [www.erdene.com](http://www.erdene.com)-оос авч танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

### Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд гуравдагч талаас авах зөвшөөрлүүд (“Зөвшөөрлүүд”) эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан

мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

**ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.**

### Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирал

Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp-/>

YouTube: <https://www.youtube.com/channel/UCILs5s9j3SLmya9vo2-KXoA>